



“ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 25-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г

Г

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүн түр томилох тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн
ТОГТООХ НЬ :

Нэг. Компанийн тухай хуулийн 77.5-д заасны дагуу нас барсан Төлөөлөн
удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ц.Эрдэнэсүхийн оронд хувьцаа
эзэмшигч Э.Мөнх-Оргилыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Б.МӨНХБАТ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН:

Э.ТЭМҮҮЖИН

С.ЭРДЭНЭЧИМЭГ

Э.УНДРАХ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Б.СУМЬЯА

Г.АМГАЛАН



“ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 25-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г

Г

Хүрд Финанс ББСБ-ын дүрмийн санг
нэмэгдүүлэх тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн
ТОГТООХ НЬ :

Нэг. Хүрд ХК-ийн хуримтлагдсан ашгаас Хүрд Финанс ББСБ-ын дүрмийн санг
500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж хөрөнгө оруулалтыг олгосугай.

Хоёр: Тогтоолын хэрэгжилтийг биелүүлж хөрөнгө оруулалт олгохыг Хүрд
ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Тэмүүжинд, хөрөнгө оруулалттай холбоотой
Санхүүгийн зохицуулах хороонд гаргах бичиг баримтын иж бүрдлийг хангаж
ажиллахыг Хүрд Финанс ХХК гүйцэтгэх захирал Г.Цэцэгээд тус тус
даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Б.МӨНХБАТ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН:

Э.УНДРАХ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Б.СУМЬЯА

Г.АМГАЛАН

Э.МӨНХ-ОРГИЛ



“ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 25-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Г

Г

*Компанийн өмчийн барилгыг буулгах,
улсын бүртгэлээс хасуулах тухай*

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн
ТОГТООХ НЬ :

Нэг. Хүрд компанийн өмч болох улсын бүртгэлийн 2202005473 дугаарт бүртгэгдсэн Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо Д.Сүхбаатарын гудамжид байрлах 100,700,000 төгрөгийн үнэ бүхий 1954 оны, ашиглалтын шаардлага хангахгүй худалдаа үйлчилгээний зориулалттай 1 давхар барилгыг зохих журмын дагуу акталж, буулгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Буулгаж байгаа худалдаа үйлчилгээний барилгыг улсын өмчийн бүртгэлээс хасуулахыг санхүүгийн албанд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Б.МӨНХБАТ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН:

Э.ТЭМҮҮЖИН

С.ЭРДЭНЭЧИМЭГ

Э.УНДРАХ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Б.СУМЬЯА

Г.АМГАЛАН

Э.МӨНХ-ОРГИЛ